**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 02 өдөр　　　　Дугаар А/132　　　　Жаргалант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.”Эрүүл чийрэг-Норовлинчууд” хөтөлбөрийн хүрээнд “Нийтийн цэнгээнт бүжгийн сумын аварга шалгаруулах тэмцээний шагналд 2139500 (хоёр сая нэг зуун гучин есөн мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Тэмцээнд шаардагдах 2139500 (хоёр сая нэг зуун гучин есөн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА　　　　Ө.ДАВААЖАРГАЛ

232501318

БАТЛАВ:
НОРОВЛИН СУМЫН ИТХ-ЫН
ДАРГА Н.ЛХАГВА

БАТЛАВ:
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.ДАВААЖАРГАЛ

## ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
## "НИЙТИЙН ЦЭНГЭЭНТ БҮЖГИЙН СУМЫН АВАРГА"
## ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

**Зорилго**: Нийтийн биеийн тамир, бүжгийн спортоор хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон, үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор "ЭРҮҮЛ ЧИЙРЭГ НОРОВЛИНЧУУД" дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, хөдөлгөөнөөр эрүүлжих, бүжгийн урлагаар дамжуулан соёлыг түгээн дэлгэрүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ, хураамж:** Норовлин сумын төрийн байгууллага, багууд, ААНэгж, ТББайгууллагууд оролцоно. Тэмцээнд оролцох хүн тус бүр 10000 төгрөгийн хураамжтай.

**Тэмцээний бүртгэл**: 2025 оны 11-р сарын 26-ны 16 цагт Норовлин сумын Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан М.Мөнхзул /Утас 80185545/, "Мандах" бүжгийн клубын ахлагч Х.Баярмандал /Утас 98114260/ нарт бүртгүүлнэ.

**Хугацаа, хаана болох**: 2025 оны 11-р сарын 29-ны өдрийн 11 цагт Норовлин сумын Соёлын төвийн бүжгийн зааланд.

**Тэмцээн зохион байгуулагч**: Норовлин сумын ЗДТГ, ЭМТ, "Мандах" бүжгийн клуб

**Зохион байгуулах төрөл**:

1. Хосын төрөл /18-49 нас/
2. Хосын төрөл /50-аас дээш нас/
3. Эмэгтэй хосын төрөл /18-45 нас/
4. Эмэгтэй хосын төрөл /46-аас дээш нас/
5. Хосын хослол /Нас, хүйс харгалзахгүй, 2 хос буюу 4 хүн/

**Дүгнэх үзүүлэлт:**

- Цаг барилт
- Талбайн хуваарилалт, сонсгол, хэмнэл
- Бүжиглэх ур чадвар, гүйцэтгэл
- Хувцаслалт

**Шагнал урамшуулал:**

1. Төрөл тус бүр дээр:

   1-р байр 100000 төгрөг, алтан медаль, өргөмжлөл
   2-р байр 80000 төгрөг, мөнгөн медаль, өргөмжлөл
   3-р байр 60000 төгрөг, хүрэл медаль, өргөмжлөл

2. Хосын хослол /18-45 нас/:

   1-р байр 200000 төгрөг, алтан медаль, өргөмжлөл
   2-р байр 160000 төгрөг, мөнгөн медаль, өргөмжлөл
   3-р байр 120000 төгрөг, хүрэл медаль, өргөмжлөл

## ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ, АНГИЛАЛ

| № | Тэмцээний төрөл | Насны ангилал | Оролцох бүжиг |
|---|---|---|---|
| 1 | Хосын төрөл | 18-49 нас | 1. Уран вальс<br>2. Школьный вальс<br>3. Адваст<br>4. Танго<br>5. Фокстрот-1 |
| 2 | Хосын төрөл | 50-дээш нас | 1. Уран вальс<br>2. Ёохор<br>3. Тустип<br>4. Вальсвостон<br>5. Фокстрот-1 |
| 3 | Эмэгтэй хосын төрөл | 18-45 нас | 1. Уран Вальс<br>2. Полька<br>3. Танго<br>4. Подостпан<br>5. Фокстрот-1 |
| 4 | Эмэгтэй хосын төрөл | 46-аас дээш нас | 1. Өндөр хоршоо<br>2. Ганган хул<br>3. Тустип<br>4. Вальсвостон<br>5. Фокстрот-1 |
| 5 | Хосын хослол | Нас, харгалзахгүй | 1. Уран вальс<br>2.Танго<br>3.Адваст |

**Бүжгийн тэмцээн явуулах журам.**

1. Насны ангилалаар тэмцээнд оролцох
2. Тэмцээнд оролцохдоо хувийн дугаараа авч бэхэлсэн байх
3. Хосын хослол төрөлд оролцогчид аяыг өөрсдөө бэлдэж ирэх

НОРОВЛИН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

“ЭРҮҮЛ ЧИЙРЭГ НОРОВЛИНЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, СОЁЛЫН ТӨВТЭЙ ХАМТРАН НИЙТИЙН ЦЭНГЭЭНТ БҮЖГИЙН СУМЫН АВРАГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

| № | ҮЙЛ АЖИЛААГАА | ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ |
|---|---|---|---|
| 1 | 18-49 насны ангилалын хосын төрөлд 1,2,3 байр 6 бүжигчин оролцсон | <br>1-р байр Мандах бүжгийн клубын ахлахч Х.Солонго, Мөнх-төгөлдөр нар<br>2-р байр ЭМТ бичиг хэргийн ажилтан Э.Ижилцэцэг, Мөнх-Оргил нар<br>3-р байр Тэмүүжинтөгс, Хэрлэнчимэг нар тус тус байр эзэлсэн | 1-байр 100,000 төг<br>2-р байр 80,000 төг<br>3-р байр 60,000 төг |
| 2 | 50- дээш насны ангилалд 1,2,3 байр 6 бүжигчин оролцсон | <br>1-р байр Ч.Наранчимэг, Гандаш нар<br>2-р байр М.Баттулга, Б.Оюунсүрэн нар<br>3-р байр Ж.Ганбаасан, Эрдэнэчулуун нар тус тус байр эзэлсэн | 1-байр 100,000 төг<br>2-р байр 80,000 төг<br>3-р байр 60,000 төг |
| 3 | 18-49 насны эмэгтэй хосын төрөлд 1,2,3 байр 6 бүжигчин оролцсон | | 1-байр 100,000 төг<br>2-р байр 80,000 төг<br>3-р байр 60,000 төг |

| | | | |
|---|---|---|---|
| | | <br>1-р байр Х.Солонго, Б.Мягмарсүрэн нар<br>2-р байр Хэрлэнчимэг, Энхжин нар<br>3-р байр Э.Ижилцэцэг, А.Хувьзаяа нар тус тус эзэлсэн | |
| 4 | 50-дээш насны эмэгтэй хосын төрөлд 1,2,3 байр 6 бүжигчин оролцсон | <br>1-р байр Б.Оюунсүрэн, Ж.Туулгуа нар<br>2-р байр Г.Бямбадаш, Х.Ганчимэг нар<br>3-р байр Ч.Наранчимэг, С.Ренчинханд тус тус байр эзэлсэн. | 1-байр 100,000 төг<br>2-р байр 80,000 төг<br>3-р байр 60,000 төг |
| 5 | Нас хүйс харгалзахгүй хосын хослол төрөлд 1,2,3 байр 4 бүжигчин 12 хос | <br>1-р байр Мөнх-Төгөлдөр, Х.Солонго, Намуун-дарь , Мөнх-Оргил нар<br>2-р байр Ренчинханд, Оюунсүрэн, Бямбадаш, Наранчимэг | 1-р байр 200,000 төг<br>2-р байр 160,000 төг<br>3-р байр 120,000 төг |

| | | | |
|---|---|---|---|
| | | 3-р байр Хувьзаяа, Ижилцэцэг, Оюунсүрэн, Мөнхсайхан нар тус тус байр эзэлсэн. | |
| 6 | 11 хүн бүжгийн сургалтанд хамрагдсан сургалтын зардал |  Мандах бүжгийн клубын ахлагч Х.Солонго, Мөнх-Төгөлдөр нар 3 өдрийн турш нийт 26 хүнд бүжгийн сургалт хийсэн. Бүжгийн сургалтын зардал нийт 330,000 төгрөг болсон | 330,000 төг |
| **НИЙТ ҮНЭ 1,770000** | | | |

ТАЙЛАН БИЧСЭН: ..................................МАНДАХ БҮЖГИЙН КЛУБЫН АХЛАГЧ Х.СОЛОНГО

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Ө.ДАВААЖАРГАЛ

## “ЭРҮҮЛ, ЧИЙРЭГ НОРОВЛИНЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗОРИЛГО:**
Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгон зан үйлийг өөрчлөх замаар бие бялдар, сэтгэц, танин мэдэхүйн хувьд эрүүл, өв тэгш, зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэх.

Эрүүл Монгол хүн гэдэг нь:
- Эрүүл чийрэг бие бялдартай
- Эрүүл саруул оюун ухаантай
- Эрүүл зан үйл, амьдрлын хэвшилтэй
- Эрүүл орчинг бүтээгч

**ЗОРИЛТ**
1. Эрүүл орчин, зөв хооллолт - Эрүүл аюулгүй, чанартай, шимт хүнс ялангуяа хүнсний ногоо, жимс жимсгэний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар зохистой хооллолтыг дэмжинэ.
2. Идэвхитэй хөдөлгөөн – Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан иргэдийн насжилтанд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг зөв тодорхойлох, тогтмол идэвхитэй хөдөлгөөн хийх мэдлэг, дадал эзэмшүүлэх, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортын ээлтэй орчин бүрдүүлнэ.
3. Эрүүл зан үйл – Өөрчлөх боломжтой эрсдэлт хүчин зүйл болох архины хортой хэрэглээ, тамхи татах, хөдөлгөөний дутагдал, жимс, хүнсний ногоо хангалттүй хэрэглэх, илүүдэл жин, даралт ихсэх зэрэг эрсдэлийг бууруулна.
4. Эрүүл мэндийн боловсрол – Ард иргэдэд орчны эрүүл мэнд, биеийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих, хадгалах, засах арга барилд сурах зарчмыг танин мэдэх, төлөвшүүлэх. Өөрөөр хэлбэл хүн өөрийгөө танин мэдэж хоол хүнсээ тохируулж хэрэглэх, ажил амралтаа зохицуулах, буруу зуршлаас зайлсхийх зэрэг наад захын эрүүл мэндийн боловсрол олгоно.

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь үзүүлэлт | | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв /₮/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь он | Суурь түвшин | | | | | | | |
| Зорилт 1: Эрүүл орчин, зөв хооллолт - Эрүүл аюулгүй, чанартай, шимт хүнс ялангуяа хүнсний ногоо, жимс жимсгэний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар зохистой хооллолтыг дэмжинэ. | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | техөөрөмж бүхий дасгалын талбайтай болох | болсон байх | | | | | | | | | | |
| 9 | Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн биеийн тамирын 2 талбайтай болох /гэрэлтүүлэг, зориулалтын хашаа бүхий нар, салхи, усанд тэсвэртэй хальтрахгүй, бат бөх, хагарч цуурахгүй, гэмтэл бэртэл учруулахгүй, шугам нь арилахгүй PVC материалаар хийсэн талбай/ | Биеийн тамирын талбайтай болсон байх | Тоо | 2024 | - | | 1 | 1 | | ЗДТГ | ЭМТ | - |
| Үйл ажиллагааны чиглэл 2. Биеийн онцлог, сонирхолд нийцсэн спорт, идэвхтэй хөдөлгөөний талаарх мэдлэг, хандлага, дадлыг эзэмшсэн идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх | | | | | | | | | | | | |
| 10 | Бүжгийн дугуйланг тогтмол хичээллүүлэх | Бүжгийн спортоор тогтмол хичээллэдэг иргэдтэй болсон байх | Тоо | 2024 | | + | + | + | + | Соёлын төв | "Мандах" бүжгийн клуб | - |
| 11 | Иргэдэд шугман бүжиг, флашмоб, орчин цагийн нийтийн цэнгээнт бүжиг заах | Бүжгийн спортоор тогтмол хичээллэдэг иргэдтэй болсон байх | Тоо | 2024 | | + | + | + | + | "Мандах" бүжгийн клуб | Соёлын төв | - |
| 12 | Жил бүр орчин үеийн нийтийн цэнгээнт бүжгийн "Сумын | Бүжгийн спортоор тогтмол | Тоо | 2024 | | + | + | + | + | "Мандах" бүжгийн клуб | Соёлын төв | 2000000₮ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аварга” шалгаруулах арга хэмжээ зохион байгуулах | хичээллэдэг иргэдтэй болсон байх | | | | | | | | | | |
| 13 | Уулаңд алхдаг иргэдийн багийг бүрдүүлж, алхалт хийх | Тогтмол алхдаг иргэдийн тоо | Тоо | 2024 | - | 10 | 20 | 30 | 40 | Төсөвт байгууллагууд, БЗД нар | ЭМТ | - |
| 14 | Өдөр бүр 30 минут болон түүнээс дээш хугацаагаар өөрийн биеийн онцлог, сонирхолд нийцсэн дасгал хөдөлгөөнийг /шаламгай алхаагаар алхах, босох суух, гүйх/ хийх дадлыг эзэмших, амьдралын хэвшил болгоход чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг олон төрлөөр зохион байгуулах | Дасгал, хөдөлгөөн хийдэг иргэдийн тоо | Тоо | 2024 | | + | + | + | + | Төсөвт байгууллагууд, БЗД нар | ЭМТ | - |
| 15 | Олон нийтийг хамарсан Fit disco, Flash mob арга хэмжээг зохион байгуулах | Зохиосон арга хэмжээний тоо | Тоо | 2024 | | 2 | 2 | 2 | 2 | Соёлын төв | “Мандах” бүжгийн клуб | 2000000₮ |
| Үйл ажиллагааны чиглэл 3. Спорт, идэвхтэй хөдөлгөөний үйлчилгээг хувийн хэвшил, спортын клубын оролцоонд тулгуурлан хөгжүүлэх, эрчимжүүлэх | | | | | | | | | | | | |
| 16 | Мэргэжлийн дасгалжуулагч бэлтгэх сургалтанд орон нутгийн боловсон хүчнийг хамруулан, бэлтгэх | Бэлтгэсэн боловсон хүчний тоо | Тоо | 2024 | - | | 1 | | | ЗДТГ | - | - |

ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
4 ДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 12 өдөр Дугаар 12 Норовлин сум

"Эрүүл чийрэг Норовлинчууд"
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1, 48.2 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, "Эрүүл мэндийн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт "Сумын засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.3.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгон, зан үйлийг өөрчлөх замаар бие бялдар, сэтгэц, танин мэдэхүйн хувьд эрүүл, өв тэгш, зөв дадал хэвшилтэй, идэвхитэй амьдралын хэв маягтай эрүүл монгол хүнийг төлөвшүүлэх зорилгоор Норовлин суманд 2025-2028 онд хэрэгжүүлэх "Эрүүл чийрэг Норовлинчууд" дэд хөтөлбөрийг хавсралтаар батлсугай.

2.Дэд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Г.Ариунзул)-д даалгасугай

3.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг сумын Засаг дарга (Ө.Даваажаргал)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, ёс зүй, сахилга хариуцлагын хорооны дарга (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ДАРГА Н.ЛХАГВА

24250260

БАТЛАВ:

ЭРХЛЭГЧ ЭМЧ........................Г.АРИУНЗУЛ

СЯБ0001 9976788

# "ЭРҮҮЛ, ЧИЙРЭГ НОРОВЛИНЧУУД" ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХҮРЭЭНД ХИЙХ 11 САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗОРИЛГО:**

Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгон зан үйлийг өөрчлөх замаар бие бялдар, сэтгэц, танин мэдэхүйн хувьд эрүүл, өв тэгш, зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай Эрүүл Монгол хүнийг төлөвшүүлэх.

Эрүүл Монгол хүн гэдэг нь:

- Эрүүл чийрэг бие бялдартай
- Эрүүл саруул оюун ухаантай
- Эрүүл зан үйл, амьдрлын хэвшилтэй
- Эрүүл орчинг бүтээгч

**ЗОРИЛТ**

5. Эрүүл орчин, зөв хооллолт - Эрүүл аюулгүй, чанартай, шимт хүнс ялангуяа хүнсний ногоо, жимс жимсгэний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар зохистой хооллолтыг дэмжинэ.
6. Идэвхитэй хөдөлгөөн – Хөдөлгөөний хомсдолоос шалтгаалан иргэдийн насжилтанд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг зөв тодорхойлох, тогтмол, идэвхитэй хөдөлгөөн хийх мэдлэг, дадал эзэмшүүлэх, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортын ээлтэй орчин бүрдүүлнэ.
7. Эрүүл зан үйл – Өөрчлөх боломжтой эрсдэлт хүчин зүйл болох архины хортой хэрэглээ, тамхи татах, хөдөлгөөний дутагдал, жимс, хүнсний ногоо хангалтгүй хэрэглэх, илүүдэл жин, даралт ихсэх зэрэг эрсдэлийг бууруулна.
8. Эрүүл мэндийн боловсрол – Ард иргэдэд орчны эрүүл мэнд, биеийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих, хадгалах, засах арга барилд сурах зарчмыг танин мэдэх, төлөвшүүлэх. Өөрөөр хэлбэл хүн өөрийгөө танин мэдэж хоол хүнсээ тохируулж хэрэглэх, ажил амралтаа зохицуулах, буруу зуршлаас зайлсхийх зэрэг наад захын эрүүл мэндийн боловсрол олгоно

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хийх ажил | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1: Эрүүл орчин, зөв хооллолт - Эрүүл аюулгүй, чанартай, шимт хүнс ялангуяа хүнсний ногоо, жимс жимсгэний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар зохистой хооллолтыг дэмжинэ.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16 | “Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо” аян зохион байгуулах | Албан байгууллага, ААН, эрчүүд Иргэйин дунд “Эрчүүдийн спортыг дэмжицгээе уриатай спорт өдөрлөг зохион байгуулах удирдамж төлөвлөгөө гаргаж ажиллах | 11-р сарын 22 | НЭМА М.Мөнхзул | Төсөвт байгууллага | - |
| | **Зорилт 4. Эрүүл мэндийн боловсрол – Ард иргэдэд орчны эрүүл мэнд, биеийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэнд, оюун санаа, бие бялдрын эрүүл мэндийн мэдлэгийг олгож, хувь хүмүүст эрүүл мэндээ хэрхэн дэмжих, хадгалах, засах арга барилд сурах зарчмыг танин мэдэх, төлөвшүүлэх. Өөрөөр хэлбэл хүн өөрийгөө танин мэдэж хоол хүнсээ тохируулж хэрэглэх, ажил амралтаа зохицуулах, буруу зуршлаас зайлсхийх зэрэг наад захын эрүүл мэндийн боловсрол олгох** | | | | | |
| 19 | “Эрүүл чийрэг Норовлинчууд” сошиал хуудас ажиллуулах | “Эрүүл чийрэг Норовлинчууд пэйж хуудас нээж зохион байгуулж байгаа үйл ажилллагаа мэдээ мэдээллийг тогтмол хийсэн ажилаа мэдээлэл оруулах | 11-р сард | НЭМА М.Мөнхзул | - | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 2. “Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг” арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 20 | 1. Хүүхдийг гараа зөв угаах дадалд сургах<br>2. Хүүхдийг шүдээ зөв угаах дадалд сургах<br>3. Хүүхдийг зөв бие засах дадалд сургах | Норовлин сумын Хүүхдийн цэцэрлэгийн эмч Т.Чанцалдулам, Ерөнхий боловсролын эмч Э.Мөнх-Эрдэнэ нартай хамтран “хүүхэд гараа хэрхэн зөв угаах дадалд суралцсан эсхэд хяналт үнэлгээ хамтарч хийх | 11-р сард 9 | НЭМА М.Мөнхзул | СӨБ, ЕБС | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 3. “Эрүүл мэндийг дэмжигч сургууль” арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 24 | “Ариун цэвэр” арга хэмжээг зохион байгуулж, суралцагчдад хэвшүүлэх /амны хөндийн, үсний, чихний, арьсны, бэлгийн, гутал, хувцасны, орчны / | Ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн хүүхдийн дунд “Ариун цэвэр” аяныг зохион байгуулах, уралдаан зарлах /Амны хөндий, үс, чих, арьсны, бэлгийн, гутлын, хувцас, орчин гэх мэт мэдээллийг ЕБС эмч нар өөрийн пэйж хуудсаар байршуулах мөн ангиудаар явж хяналт үнэлгээ хийх | 11-р сард 9 | НЭМА М.Мөнхзул | ЕБС-н Эмч Э.Мөнх-Эрдэнэ | - |
| **Үйл ажиллагааны чиглэл 5. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр мэтгэлцээн зохион байгуулах** | | | | | | |
| 27 | “Эрүүл ажлын байр” мэтгэлцээн зохион байгуулах | Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын дунд “Эрүүл ажлын байр” мэтгэлцээн сарын хугацаатай ажлыг зохион байгуулах 1,3,5 өдөр ажлын байраар хяналт үнэлгээ хийх | 11-р сарын 1нээс 12-р сарын 30 хүртгэл | НЭМА М.Мөнхзул | ЗДТГ | - |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

НЭМА.........................М.МӨНХЗУЛ